

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ

Нэг.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хүмүүнлэгийн ухааны их сургууль /цаашид “сургууль” гэх/-ийн хичээлийн байрны дотоод журам /цаашид “журам” гэх/-аар сургуулийн хичээлийн байранд баримтлах дэг, хичээллэх журамтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмыг сургуулийн нийт багш, ажилтнууд болон суралцагчид дагаж мөрдөнө.

1.3 “Хичээлийн байр” гэдэгт багш, ажилтнууд, суралцагчидын сурч, ажиллах хэвийн нөхцлийг хангахуйцаар зохион байгуулагдсан өрөө, анги танхим, лаборатори, кабинет, ариун цэврийн өрөө, коридор, номын сан, хоолны газрын талбайг ойлгоно.

1.4. Нэр томъёо:

“танхайрах буюу нийгмийн хэв журмыг зөрчих” гэдэгт хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөж хоргоох, олон нийтийг илтэд үл хүндэтгэн элдэв цээртэй хараалын болон бусдын нэр төрийг басамжлан доромжилсон үгийг ичгүүргүйгээр зарлан түгээх, бусдыг доромжилох, гүтгэх, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах, эдгээр шинжийг агуулсан захиа, дүрс илгээх, дамжуулах, бусад руу хүч хэрэглэн довтолох, зодох, ингэхдээ элдэв юмсыг эсхүл зэвсэг хэрэгсэл түүнтэй адилтгах зүйлсийг хэрэглэх, хэрэглэхээр завдах эсхүл үүнийгээ хатуу ширүүн үгээр илэрхийлэн орчны хүмүүсийг айлган сүрдүүлж түгшээх, жигшил дургүйцлийг төрүүлэх зэргээр хэрцгий догшин авирлан нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн шууд санаатай үйлдлийг;

“ялгаварлан гадуурхах” гэдэгт арьс үндэс, арьсны өнгө, хүйс шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа буюу нийгмийн гаралд үндэслэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, хичээл сургалтын явцад тэгш боломж, хандлагыг үгүйсгэх, эсхүл зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлан гадуурхах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг

“хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэгт өлгүүрчин ажлын байрандаа байгаагүйн улмаас гадуур хувцасаа өлгүүлж чадаагүй, хувийн зайлшгүй шалтгаанаар малгай, нарны шил зүүх шаардлагатай болсон тохиолдлыг;

“сургуулийн эд хөрөнгө” гэдэгт сургуулийн эзэмшил, санхүүгийн тайлан тэнцэл, бүртгэлд байгаа өөрийн бүх эд хөрөнгийг;

“зориулалтын бус газар” гэдэгт хог хаягдал хадгалах зориулалтын цэг буюу хог хаягдал цуглуулах зорилгоор байгуулсан зориулалтын сав, байгууламжаас бусад газрыг;

“сургуулийн ойр орчин” гэдэгт сургуулийн байрнаас 500 метрийн доторх талбайг ойлгоно.

Хоёр. ХИЧЭЭЛИЙН БАЙРАНД БАРИМТЛАХ ДЭГ

2.1. Хичээлийн байранд дараах үйлдэл, үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

2.1.1. Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм зөрчих;

2.1.2. Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд малгай, нарны шил, гадуур хувцастай явах;

2.1.3. Танхайрах буюу нийгмийн хэв журмыг зөрчих;

2.1.4. Ялгаварлан гадуурхах;

2.1.5. Зориулалтын бус газар хог хаягдал хаях, цонхны тавцан, ширээн дээр суух, сургуулийн эд хөрөнгө дээр ямар нэг зүйл бичих, тэмдэглэх, зурах, наах гэх зэргээр сургуулийн эд хөрөнгийг гамгүй эдэлж, эвдэлж, гэмтээх, сүйтгэх, ашиглах боломжгүй болгох;

2.1.6. Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл, галт зэвсэг, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис оруулах, авч явах, хадгалах;

2.1.7. Ажлын зайлшгүй шаардлагатай нөхцлийн дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хутга, мэс, бусад хүйтэн зэвсгийг зэвсгийн чанартайгаар биедээ авч явах;

2.1.8. Ажлын болон хичээл сургалтын цагаар бусдад саад болох, ажил хичээлийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулах, ажлын өрөө, хичээлийн анги танхимд зөвшөөрөлгүй нэвтрэх;

2.1.9. Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад бусдад саад болохуйц чанга дуугаар ярих, чимээ шуугиан гаргах, гүйх, дуу хөгжим чанга дуугаргах, гар утсаар ярих, бохь зажлах, хүнсний зүйлс хэрэглэх;

2.1.10. Сургуулийн захиргаа, холбогдох албан тушаалтны бичгийн зөвшөөрөлгүйгээр хичээлийн байрнаас сургуулийн эд хөрөнгө зөөх, шилжүүлэх, авч гарах;

2.1.11. Хичээлийн хуваарьт өрөөг дур мэдэн солих, зориулалтын бусаар ашиглах;

2.1.12. Хичээлийн байранд болон сургуулийн ойр орчинд мансууруулах бодис, согтрууруулах ундаа хэрэглэх, уух, худалдах, дамжуулах, бэлэглэх, согтуугаар хичээлийн байранд нэвтрэх, сэлгүүцэх;

2.1.13. Түргэн тусламж, цагдаа, гал усны аюулд тусламж дуудахаас бусад хэрэгцээнд жижүүрийн утас ашиглах;

2.1.14. Цонх, салхивч, усны цорго онгорхой орхих;

2.1.15. Хууль тогтоомж, нийгмийн хэв журам, сургуулийн дүрэм, журам, зааврыг зөрчих, сургалтын шинжлэх ухааны үзэл баримтлалын эсрэг чиглэсэн ухуулга, сурталчилгаа явуулах;

2.1.16. Сургуулийн захиргааны зөвшөөрөлгүй хичээлийн байранд жагсаал, цуглаан зохион байгуулах;

2.1.17. Зөвшөөрөгдсөнөөс бусад газарт худалдаа, үйлчилгээ явуулах;

2.1.18. Хичээлийн байрны цахилгаан ба сантехникийн тоног төхөөрөмжийг дур мэдэн оролдох, өөрчлөх, солих, салгах;

2.1.19. Хичээлийн хуваарь зөрчсөн, хуваарьт ангидаа хичээл ороогүй, хожимдож орсон, түрүүлж завсарлах;

2.1.20. Сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн болон захирлын зөвшөөрөлгүйгээр хичээлийн цагаар багш, суралцагчийг хичээл таслуулж дуудах, өөр ажил хийлгэх;

2.1.21. Оройн 21 цагаас хойш болон амралт, баяр ёслолын өдөр багшгүй эсхүл сургуулийн захирлын бичгээр өгсөн зөвшөөрөлгүй хичээлийн байранд ямар нэг үйл ажиллагаа явуулах;

2.1.22. Захирлын зөвшөөрөлгүйгээр анги танхимыг сургалтын бус зориулалтаар болон тухайн сургуулийн бус хүмүүст ашиглуулах;

2.1.23. Сургуулийн бус хүмүүсийг зөвшөөрөлгүйгээр хичээлийн байранд оруулах;

2.1.24. Тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг бүхий газар болон сургууль дотор, сургуулийн ойр орчинд утаат тамхи татах;

2.2. Сургуулийн багш, ажилтан, суралцагч нь дараах үүрэгтэй:

2.2.1. Хичээлийн байрны журам зөрчсөн этгээдэд шаардлага тавих, зөрчлийг арилгуулах;

2.2.2. Хичээлийн байранд орохдоо шаардлагатай бол ажлын үнэмлэх, бичиг баримтаа жижүүрт шалгуулах;

2.2.3. Хичээлийн байрны ариун цэврийг сахих, сургуулийн эд хөрөнгийг ариг гамтай ашиглах, хэрэглэх, бүрэн бүтэн байдалд нь хяналт тавих;

2.2.4. Сонор сэрэмжтэй байж аливаа осол, зөрчил, аюул бүхий байдлыг мэдсэн даруйдаа холбогдох албан тушаалтан, хичээлийн байрны зохицуулагч болон жижүүрт шуурхай мэдэгдэх;

2.2.5. Сургуулийн эд хөрөнгийг шилжүүлэн зөөх, гадагш авч гарах тохиолдолд тухайн эд хөрөнгийг хариуцсан хүмүүст бүртгүүлж гарын үсэг зурж баталгаажуулах;

2.2.6. Хичээлийн байранд орой 21.00 цагаас хойш болон амралт, баяр ёслолын өдөр ажиллах шаардлагатай бол сургуулийн захиргаа, холбогдох албан тушаалтнаас заавал бичгээр зөвшөөрөл авах;

2.2.7 Хичээл сургалтын болон ажлын цаг дууссаны дараа багш, ажилтан нь тухайн анги танхим, өрөө тасалгааны техникийн аюулгүй байдлыг шалган, цоожилж /лацдаж/, түлхүүрийг нь жижүүрт хүлээлгэн өгөх;

Гурав. ХИЧЭЭЛЛЭХ ЖУРАМ

3.1. Сургуулийн хичээл, сургалтын ажил нь сургалтын төлөвлөгөөний дагуу хуваарилсан анги, танхимд явагдана. Хичээлийн цагийн хуваарийг хагас жил тутамд зохиох ба хичээл эхлэхээс 7 хоногийн өмнө Сургалт, судалгааны хөгжил, аудитын үйлчилгээний алба (ССХАҮА)-аас гаргасан байна.

3.2. Хичээлийн үргэлжлэх хугацаа 90 минут, хичээл хоорондын завсарлага 10 минут байна.

3.3. Багш, суралцагчад хичээл эхлэхээс 10 минутын өмнө ирж, хичээлийн бэлтгэлээ бүрэн хангасан байна.

3.4. Туслах ажилтан хичээл эхлэхээс 10 минутын өмнө ирж тухайн хичээлд шаардлагатай техник хэрэгсэл, үзүүлэн материал, техник хэрэгсэл, гарын авлага зэргийг хичээлийн өрөө, анги, танхимд бэлэн байлгах үүрэгтэй.

3.5. Хичээлд гадны хүн суух бол ССХАҮА-ны даргын зөвшөөрлийг бичгээр заавал авна.

3.6. Шаардлагатай тохиолдолд тэнхимийн эрхлэгч хуваарьт хичээлийг өөр багшаар заалгаж, ССХАҮА-ны даргын зөвшөөрөлтэйгээр хичээлийн хуваарийг өөрчилж болно. Хичээлийн явцыг ССХАҮА болон тус албаны менежер хянана.

3.7. Анги бүр захирлын тушаалаар томилогдсон зөвлөх багштай байна. Зөвлөх багш нь тухайн ангийн суралцагчдад сурлага, соёл, хүмүүжлийн талаар зөвлөгөө өгөх үүрэгтэй.

Дөрөв. ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу захирлын тушаалаар зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

4.2 Сургуулийн эд хөрөнгийг эвдэж, гэмтээсэн болох нь холбогдох баримтаар тогтоогдсон бол тухайн эвдэж, гэмтсэн эд хөрөнгийг зах зээлийн ханшнаас 3 дахин нэмэгдүүлсэн үнээр төлүүлнэ.

4.3. Хичээлийн байранд гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан этгээдийг харьяалагдах цагдаагийн байгууллагад мэдэгдэж, шилжүүлж өгнө.

4.4. Хичээлийн байранд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг цагдаагийн албан хаагчид хүлээлгэн өгнө.